

## ТАНИЛЦУУЛГА

*Журам батлах тухай Хөдөлмөр,  
нийгмийн хамгааллын сайдын тушаалын  
төсөл боловсруулсан тухай*

Нийгмийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм"-д заасны дагуу нийгмийн даатгалын байгууллагад 2-оос доошгүй жил ажилласан ажилтнаас улсын байцаагчийн, нийгмийн даатгалын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан ажилтнаас улсын ахлах байцаагчийн шалгалт авах, шалгалтад тэнцсэн ажилтанд улсын болон ахлах байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх, түдгэлзүүлэх, цуцлах харилцааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/27 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, эрх баталгаажуулах, эрх сэргээх шалгалтын журам"-ын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталсан бөгөөд хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэгт "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрхийг олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлахтай холбогдсон харилцааг зохицуулсан журам, улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн загварыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Журам батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл, журмын төслийг тус тус боловсруулав.

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 1 480 байцаагч, ажилтан ажиллаж байгаа бөгөөд 576 нь улсын байцаагчийн, 37 нь улсын ахлах байцаагчийн эрхтэй ажиллаж байна.

Энэхүү тушаал батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

---oOo---